**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 30 өдөр  Дугаар А/273  Бат-Өлзий сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой, хээрийн түймэр, хууль бус мод, хуш модны самар бэлтгэхээс урьдчилан сэргийлэх болон хорио цээр тогтоосон үед явуулын хяналтын пост ажиллуулахад шаардлагатай вагончик худалдан авах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батдорж (Засаг даргын орлогч)
Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)
Б.Пүрэвсүрэн (Засаг даргын Тамгын газрын нятлан бодогч)
Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангуулж хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Б.Батдорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Н.ОРХОНТУУЛ

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

-622301481